



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

15170 Улаанбаатар хот, 40, 50 мянгат-1,  
Ж.Самбуугийн гудамж, Утас: 26-15-44

2013.12.13 № 1-3321

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Материал хүргүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.2, Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.7, 25 дугаар зүйлийн 25.2.9, 25.3-т зааснаар Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудлыг 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Улсын Дээд шүүхийн шүүгчдийн зөвөлгөөнөөр хэлэлцэн шийдвэрлэлээ.

Улсын Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлсэн Дамдинсүрэн овогтой Солонго, Шар овогтой Цогтоо нарт холбогдох 62 хуудас материалыг хавсарган хүргүүлэв.

Хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.

Хүндэтгэсэн;

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Ц.ЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ  
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЦЭЦИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙГ  
САНАЛ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2, Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.7, 25 дугаар зүйлийн 25.2.9, 25.5-д заасныг удирдлага болгон Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгох тухай асуудлаар Улсын Дээд шүүхийн шүүгчдээс саналыг нууцаар хурааж, дүнг илтгэх комиссын 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2 дугаар тогтоолыг үндэслэн Улсын Дээд шүүхийн шүүгчдийн зөвөлгөөнөөс ТОГТООХ нь:

1. Улсын Дээд шүүхийн шүүгчдийн 62 хувийн санал авсан Дамдинсүрэн овогтой Солонго, 53 хувийн санал авсан Шар овогтой Цогтоо нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэн, Улсын Их Хуралд санал болгосугай.


ЗӨВЛӨГӨӨН УДИРДАГЧ  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Ц.ЗОРИГ

Б.УНДРАХ

## ТАНИЛЦУУЛГА

- |   |   |   |
|---|---|---|
| <b>1. Овог, нэр:</b>  | <b>Шарын ЦОГТОО</b>   |  |
| <b>2. Хэзээ, хаана төрсөн:</b>  | 1954 онд Сүхбаатар аймгийн Халзан суманд төрсөн.  |   |
| <b>3. Нас, хүйс:</b>  | 59 настай, эрэгтэй  |   |
| <b>4. Үндэс угсаа:</b>  | Халх  |   |
| <b>5. Ам бүлийн байдал:</b>   | Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг.   |   |
| <b>6. Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:</b> | <ul style="list-style-type: none"><li>-1975 онд Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотын 10 жилийн дунд сургууль;</li><li>-1976-1981 онд ЗХУ-ын Воронежны их сургуулийн хуулийн анги;</li><li>-1985 онд ЗХУ-ын Москвагийн хуулийн удирдах ажилтны дээд курс;</li><li>-1986-1988 онд Намын дээд сургуулийн захиргааны анги;</li><li>-2007 онд ХБНГУ-ын Мьохен хотын захиргааны хэргийн шүүгчийн сургалт;</li><li>-Хуульч, эрх зүйч мэргэжилтэй;</li><li>-Хууль зүйн ухааны доктор, профессор.</li></ul>  |   |
| <b>7. Ажилласан байдал:</b>   | <ul style="list-style-type: none"><li>-1981-1986 онд Сүхбаатар аймгийн гүйцэтгэх захиргаанд хуулийн зөвлөх, ахлах зөвлөх, хуулийн хэлтсийн дарга;</li><li>-1988-1992 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлд референт;</li><li>-1992-1996 онд Монгол Улсын Их сургууль, Удирдлагын акедемид багш, ахлах багш, тэнхимийн орлогч эрхлэгч ;</li><li>-1996-2001 онд Гаалийн ерөнхий газрын дэд дарга;</li><li>-2002-2013 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд Төрийн захиргааны эрх зүйн тэнхимийн профессор;</li><li>-2013 оноос “Чингэс хаан” Олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын даргаар ажиллаж байна.</li></ul> |   |

## ТАНИЛЦУУЛГА

- 1. Овог, нэр:** Дамдинсүрэнгийн СОЛОНГО
- 2. Хэзээ, хаана төрсөн:** 1958 онд Улаанбаатар хотод төрсөн.
- 3. Нас, хүйс:** 55 настай, эмэгтэй
- 4. Үндэс угсаа:** Халх
- 5. Ам бүлийн байдал:** Нөхөр, 2 хүүхдийн хамт амьдардаг.
- 6. Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:**
- 1966-1976 онд Нийслэлийн 10 жилийн 21 дүгээр дунд сургууль;
  - 1977-1983 онд ЗХУ-ын Москвагийн их сургуулийн хууль зүйн факультет;
  - 1979-1980 онд ЗХУ-ын Москвагийн их сургуулийн дэргэдэх Улс төрийн их сургууль;
  - Эрх зүйч мэргэжилтэй;
  - Хууль зүйн ухааны доктор, дэд профессор.
- 7. Ажилласан байдал:**
- 1983 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд багш;
  - 2000 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрдэмийн зөвлөлд эрдэмтэн нарийн бичгийн дарга;
  - 2007 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Төрийн захиргааны эрх зүйн тэнхимийн эрхлэгч;
  - 2011 оноос Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирлаар ажиллаж байна.

